



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 4/195

Баян-Өндөр сум

Ээлжит бус хуралдаан  
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсгүүд, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг"-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит бус IX хуралдааныг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр танхим, цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл хангасугай. Үүнд:

1. Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай;

2. "Нийтлэг үйлчилгээний алба" УТҮГ-ын дүрэм, орон тоо, цалин хөлсний нийтлэг жишгийг шинэчлэн батлах тухай;


3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/31 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явц байдлын тухай;

4. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IX хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ний  
өдрийн 11/19 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ БУС IX ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IX хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XII/16-нд багтаан

Ажлын алба

2.“Орхон аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/15, XII/18, XII/24-ний дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3.“Нийтлэг үйлчилгээний алба” УТҮГ-ын дүрэм, орон тоо, цалин хөлсний нийтлэг жишгийг шинэчлэн батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/15, XII/18, XII/24-ний дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/31 дүгээр тогтоолын хэрэгжилтийн явц байдлын тухай асуудлын танилцуулга, мэдээллийг Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/15, XII/18, XII/24-ний дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

5. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/15, XII/18, XII/24-ний дотор Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

6.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох Хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XII/18, XII/19-ний дотор

Холбогдох Хороод

7.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XII/23-ны дотор

Ажлын албаны дарга Ш.Ганболд

**АЖЛЫН АЛБА**